



MOORE

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ТАХЬКО ХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон
санхүүгийн тайлангийн аудит

Улаанбаатар 2024

ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН

АГУУЛГА

БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

ЗАХИРЛУУДЫН БОЛОН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	1-4
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	5
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	6-7
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	8
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	9-10
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	11-42

ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИ

БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Үүсгэн байгуулах шийдвэр	<p>"Тахько" Хувьцаат компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу 1992 оны 03 сарын 05-ны Засгийн газрын өмч хувьчлалын комиссын №32 тогтоолоор хувьчлагдан доорх нэр бүхий гишүүдийн эзэмшил Хувьцаат Компани болон өөрчлөгдсөн.</p> <p>Компани нь Монгол Улсын Бүртгэлийн Газарт 1992 оны 05 сарын 13-ны өдөр бүртгэгдсэн.</p> <p>Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9010001029, байгууллагын регистрийн дугаар 2061007.</p>
Хувьцаа эзэмшигчид	<p>Эргэлтэд байгаа энгийн хувьцааны 46.89%-ийг Монгол улсын иргэн Л. Буянбат, 31.13%-ийг Монгол улсын иргэн Ж. Чимэдцэрэн, 6.24%-ийг Монгол улсын иргэн, Гүйцэтгэх захирал Л. Энхнасан, 15.74%-ийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.</p>
ТУЗ-н гишүүд	<p>Л. Буянбат, ТУЗ-ийн дарга Ш. Мөнх-Очир, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л. Дашмягмаржав, ТУЗ-ийн гишүүн Т. Доржготов, ТУЗ-ийн гишүүн Д. Минжмаа, ТУЗ-ийн гишүүн Г.Оюунгэрэл, ТУЗ-ийн гишүүн Ж. Чимэдцэрэн, ТУЗ-ийн гишүүн Ё. Рэнцэндорж, ТУЗ-ийн хараат бус гишүүн С. Итгэл, ТУЗ-ийн хараат бус гишүүн Б. Сийлэгмаа, ТУЗ-ийн хараат бус гишүүн</p>
Гүйцэтгэх удирдлага	<p>Гүйцэтгэх захирал Л. Энхнасан Ерөнхий нягтлан бодогч Б. Сольрагчаа</p>
Байнгын хаяг	<p>Компанийн бүртгэлтэй хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж 18 тоот.</p>
Аудиторууд	<p>"Мүүрь Аудит" ХХК</p> <p>Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчид болон багийн гишүүд:</p> <p>Ахлах менежер П. Нарантуяа</p> <p>Аудитор Д. Бямбадэлгэр</p> <p>Аудитын туслах Б. Хонгорзул</p>



**ТАХЬКО (ХК) КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж-18, УБД 9010001029
Утас: 976-11-324738, Факс: +976-11-325051
И-мэйл: info@takhico.mn, Веб хуудас: www.takhico.mn

2024.04.16 № 12
танай _____-ны № _____-т

“МҮҮРЬ АУДИТ” (ХХ) КОМПАНИД

Мэдэгдэл

**“ТАХЬКО” (ХК) КОМПАНИЙН ЗАСАГЛАХ УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН
МЭДЭГДЭЛ**

“ТАХЬКО” (ХК) компанийн Гүйцэтгэх удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлэх үүрэгтэй.

Засаглах удирдлага нь Компанийн тухай хуулийн 81.4.1-д заасны дагуу компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг СТОУС-т нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү болон үйл ажиллагааны бусад мэдээллийн үнэн зөв бодит байдалд хяналт тавих үүрэгтэй.

Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журамд нийцүүлэн бэлтгэхэд хяналт тавьж ажилласнаа үүгээр мэдэгдэж байна.

“ТАХЬКО” (ХК) компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА


Л. БУЯНБАТ

ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИ
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Тахько ХК-ийн удирдлага бид санхүүгийн тайлангаа бэлтгэх явцад Хараат бус аудиторын тайлан дахь *Санхүүгийн тайлангийн аудитад удирдлагын хүлээх үүрэг хариуцлага* хэсэгт дурдсан үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрч байна гэдгийг мэдэгдэж байна.

Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн удирдлагаас 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



Л. ЭНХНАСАН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Огноо: 2024.04.16

A blue ink signature of B. Solbrigcha, written over a horizontal line.

Б. СОЛЬБРАГЧАА
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Огноо: 2024.04.16

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ТАХЬКО ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санхүүгийн тайлангийн Аудитын тайлан

Дүгнэлт

Бид, ТАХЬКО ХК-ийн (цаашид Компани гэх) 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь Компанийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу, бүх материаллаг зүйлийг хамруулан, үнэн зөв толилуулагдсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад нөлөө бүхий асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дараах гол асуудлыг тодорхойлсон ба тусад нь дүгнэлт гаргаагүй.

Бусад авлагын талаар

Тайлант оны эцсийн байдлаар компани 406,707 (2022:294,361) мянган төгрөгийн бусад авлагатай бөгөөд авлагын талаар Тодруулга 24 ба 31-т тайлбарласан.

Бид аудитын явцад 160,000 мянган төгрөгийн санхүүгийн хөрөнгийг бусад авлага руу ангилж, залруулсан.

Компанийн удирдлага бусад авлагыг дараагийн тайлант онд бүрэн төлөгдөнө гэсэн итгэлтэй байгаа бөгөөд эдгээр авлагатай холбоотой ямар нэг алдагдал хүлээн зөвшөөрөөгүй.

Бид бусад авлагатай холбоотойгоор удирдлагын үнэ цэний бууралтын талаарх ойлголтыг судалж, авлагын насжилтын шинжилгээ хийж, авлагын барагдуулалтын талаарх ирээдүйн мэдээлэл, таамаглалыг үнэлэх горим хэрэгжүүлсэн.

Дахин үнэлгээний талаар

Тайлант онд Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн хараат бус үнэлгээчнээр санхүүгийн тайлангийн зорилгоор 2023.12.31-ний өдрөөрх барилга байгууламжийн дахин үнэлгээ хийлгэсэн. Уг үнэлгээгээр барилга байгууламж болон дахин үнэлгээний нэмэгдлийн данс 3,396,843 мянган төгрөгөөр нэмэгдсэн (Тод.14,16).

Бид хараат бус үнэлгээчний үнэлгээнд ашигласан арга хандлага, төсөөлөл, тооцооллыг үндэслэлтэй гэж үзсэн бөгөөд үнэлгээний үр дүнг зөв бүртгэсэн эсэх, ашигласан арга хандлага, төсөөлөл нь ул үндэслэлтэй эсэх, үнэлгээчин нь хараат бусаар ажилласан эсэхийг үнэлсэн (Тод.17).

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ залилан юм уу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргахад байдаг. Ул үндэслэлтэй нотолгоо нь баталгааны өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгддэг аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг цаг ямагт илрүүлж байна гэсэн амлалт өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилангаас эсвэл алдаанаас үүсэж болох ба дангаараа нийлээд материаллаг болж эдгээр алдаа нь санхүүгийн тайлангууд дээр суурилан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай гэж үзсэн үед материаллаг буруу илэрхийллийг авч үзнэ.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн үнэлэмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримталдаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл харуул хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг.

Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үздэг учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Аудитын дүгнэлт нь бусад мэдээллийг хамруулаагүй буюу бид үүнтэй холбоотой ямар нэгэн баталгаажуулалт хийгээгүй болно.

Бидний гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг уншиж танилцан, бусад мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан аудиторын мэдлэгээс материаллаг зөрүүтэй эсэхийг тодорхойлох үүрэгтэй. Хэрэв бусад мэдээлэл нь материаллаг зөрүүтэй бол бид энэ тухай тайлагнах үүрэгтэй.

ТАХЬКО ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бусад мэдээллийг бид хянаж үзсэн бөгөөд аудитын тайлангийн өдрөөр 2023 оны 09 сарын 30-ны өдрөөрх үйл ажиллагааны тайлан бэлтгэгдсэн байсан тул тус тайланд тусгагдсан мэдээллүүдийг хянаж үзсэн ба нь бидний аудитад ашигласан дүнгээс материаллаг зөрүүгүй байна. Тиймээс бусад мэдээллийн талаар тайлагнах зүйлс байхгүй.

Бусад асуудал

Сонирхлын зөрчилтэй ба их хэмжээний хэлцэл

Бид тайлант онд их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл гарсан эсэхийг хянасан ба тайлант онд тийм хэлцлүүд хийгдээгүй.

Тайлан хэрэглэгчид

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, ТАХЬКО ХК-ийн Монгол улсын Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасан хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан бөгөөд бусад этгээдэд зориулагдаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.



МЭРГЭЖЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ

Хаяг: Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж 7/3 байр, Centrum төв, 7 давхар 701 тоот.

Утас: 976-70150003, **И-мэйл:** info@moore-mongolia.mn

ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИ
АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН

	Тод	Аудитлагдсан 2023.12.31 мян.төг	Аудитлагдсан 2022.12.31 мян.төг
Гэрээний орлого	7	3,186,128	3,161,350
Үйлчилгээний өртөг	8	(1,172,908)	(1,150,112)
Нийт ашиг		2,013,220	2,011,238
Үйл ажиллагааны зардал	9	(1,535,216)	(1,686,582)
Санхүүгийн орлого	10	326,544	261,615
Бусад орлого	11	10,763	35,931
Хөрөнгийн бодит үнэ цэний өөрчлөлтөөс үүссэн олз	11 18	46,389	-
Бусад зардал	12	(125,234)	(295,299)
Татвар төлөхийн өмнөх ашиг		736,466	326,903
Орлогын татварын зардал	13	(82,479)	(74,359)
Тайлант жилийн цэвэр ашиг		653,987	252,544
Бусад дэлгэрэнгүй орлого			
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	17	3,396,843	-
Нийт дэлгэрэнгүй ашиг		4,050,830	252,544
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг (төгрөг)		550	212

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

**ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИ
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тод	Аудитлагдсан 2023.12.31 мян.төг	Аудитлагдсан 2022.12.31 мян.төг
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	15	13,651,302	11,184,689
Биет бус хөрөнгө	16	1,522	2,855
Хойшлогдсон татварын хөрөнгө	14	393,874	415,593
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө	18	296,534	-
Зээлийн авлага	19	44,220	70,186
Хойшлогдсон НӨАТ	20	65,774	74,162
Нийт эргэлтийн бус хөрөнгө		14,453,226	11,747,485
Эргэлтийн хөрөнгө			
Бараа материал	21	60,664	59,634
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	22	403,016	403,016
Зээлийн авлага	19	25,966	22,817
Бондоорх хөрөнгө оруулалт	23	-	500,000
Бусад санхүүгийн хөрөнгө	25	1,739,700	2,304,548
Хойшлогдсон НӨАТ	20	15,628	14,156
Урьдчилж төлсөн төлбөрүүд	24	782,833	60,923
Худалдааны ба бусад авлага	24	464,104	367,111
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	26	2,683,300	1,174,200
Нийт эргэлтийн хөрөнгө		6,175,211	4,906,405
НИЙТ ХӨРӨНГӨ		20,628,437	16,653,890
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР			
Өмч			
Хувьцаат капитал	27	199,564	199,564
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	17	13,670,732	10,273,889
Хуримтлагдсан ашиг	28	6,455,704	5,930,008
Нийт өмч		20,326,000	16,403,461

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИ
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тод	Аудитлагдсан 2023.12.31 мян.төг	Аудитлагдсан 2022.12.31 мян.төг
Өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөр			
Хойшлогдсон татварын өр	14	112,894	84,773
Нийт урт хугацаат өр төлбөр		112,894	84,773
Богино хугацаат өр төлбөр			
Худалдааны болон бусад өглөг	29	162,887	138,700
Бусад татварын өр	29	22,047	20,187
Орлогын татварын өр	29	4,609	6,769
Нийт богино хугацаат өр төлбөр		189,543	165,656
Нийт өр төлбөр		302,437	250,429
НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		20,628,437	16,653,890



Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИ
 ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН

	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний	Хуримтлагдсан ашиг	Дүн
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2022.01.01-нээрх үлдэгдэл	199,917	10,273,889	5,805,755	16,279,561
Тайлант үеийн цэвэр ашиг			252,544	252,544
Халаасласан хувьцаа	(353)	-	-	(353)
Зарласан ногдол ашиг	-	-	(128,291)	(128,291)
2022.12.31-нээрх үлдэгдэл	199,564	10,273,889	5,930,008	16,403,461
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	653,987	653,987
Зарласан ногдол ашиг	-	-	(128,291)	(128,291)
Дахин үнэлгээний нэмэгдлийн дүн	-	3,396,843	-	3,396,843
2023.12.31-нээрх үлдэгдэл	199,564	13,670,732	6,455,704	20,326,000

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	Тод	АУДИТЛАГДСАН 2023.12.31 мян.төг	АУДИТЛАГДСАН 2022.12.31 мян.төг
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Татварын өмнөх ашиг		736,466	326,903
<i>Тохируулга:</i>			
Үндсэн хөрөнгийн элэгдэл	8, 9	820,172	774,571
Хорогдлын зардал	8, 9	1,333	1,763
Санхүүгийн зардал (орлого)	10	(326,544)	(261,615)
Гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит бус (олз) гарз, цэвэр	11, 12	22,634	(25,214)
Үндсэн хөрөнгө болон БЗЭБЭХөрөнгө борлуулсаны гарз	12	-	6,455
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	12	780	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн бодит үнэ цэний олз	12	(46,389)	-
Зээлийн авлагын хорогдуулга	12	-	2,718
Зээлийн хүүгийн орлого	11	(10,763)	(10,717)
<i>Ажлын капиталын тохируулга:</i>			
Худалдааны ба бусад авлага эргэлтийн хөрөнгийн (өсөлт) /бууралт	24	(818,903)	(17,279)
Худалдааны ба бусад өглөгийн өсөлт /(бууралт)	29	26,047	45,528
Бараа материалын (өсөлт) /бууралт	21	(1,030)	(9,722)
Төлсөн орлогын татвар	13	(1,778)	(7,420)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		402,025	825,971
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
БЗЭБЭХөрөнгийн өөрчлөлт	11	-	337,273
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	11	-	27,273
Үндсэн хөрөнгө худалдаж авахад төлсөн мөнгө	15	(140,867)	(1,176,109)
Зээлийн авлагын эргэн төлөлт	19	30,780	33,581

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ТАХЬКО ХУВЬЦААТ КОМПАНИ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН**

	АУДИТЛАГДСАН 2023.12.31 мян.төг	АУДИТЛАГДСАН 2022.12.31 мян.төг
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хугацаат хадгаламжийн эргэн төлөлт	4,816,548	4,608,091
Хугацаат хадгаламж дахь хөрөнгө оруулалт	(4,500,000)	(4,651,000)
Бондоорх хөрөнгө оруулалтын эргэн төлөлт	500,000	800,000
Бондоорх хөрөнгө оруулалт	-	(500,000)
Бусад эргэлтийн бус хөрөнгийн эргэн төлөлт	248,300	(2,125,000)
Бусад эргэлтийн бус хөрөнгөд оруулсан		1,337,000
Бусдад олгосон зээл	-	(30,200)
Хүлээн авсан хүү	303,240	255,278
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	1,258,001	(1,083,303)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Ногдол ашиг төлсөн	(128,291)	(128,291)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(128,291)	(128,291)
Валютын ханшийн тэгшитгэлийн бодит бус олз	(22,635)	(25,214)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,509,100	(410,837)
Мөнгөний эхний үлдэгдэл	1,174,200	1,585,037
Мөнгөний эцсийн үлдэгдэл	2,683,300	1,174,200

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү аудитлагдсан санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.